


ДЭЛХИЙН ӨВ-ОРХОНЫ ХӨНДИЙН СОЁЛЫН ДУРСГАЛТ ГАЗАР ДАХЬ СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ


Монголчуудын оюуны үнэт өв болох соёлын биет бус өв, түүний 7 ай савын олон төрөл зүйлийн илэрхийллүүд нь тус бүрдээ өөр өөрийн онцлогт шинж чанаруудыг агуулсан байх ба тэр уламжлалт чанар нь эдүгээг хүртэл хадгалагдан ирсэн байна.

Иймээс өвөг дээдсийнхээ бүтээсэн өв соёл, ёс заншил, зан үйлээ хэрэглэх нь ховордох, улмаар мартах, гээх байдал ажиглагдаж байна.

Бид энэ удаад санал асуулга боловсруулан соёлын биет бус өв, түүний төрлүүдийг илэрхийлэх, өвлөн уламжлагчдыг тодруулахаар Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газар холбогдох 2 аймгийн 5 сумын 1689 хүнээс түүврийн аргаар судалгаа авч анализ хийж үзлээ.



Соёлын биет бус өвийн төрлийн хэрэглээний судалгаа авч, анализ хийж үзэхэд 7 ай савын 122 төрлийн соёлын биет бус өв тодорхойлогдсон бөгөөд аман өв уламжлалыг сонгон авч, түүний 17 төрөл зүйлийн өнөөгийн хэрэглээний байдлыг тодорхойлон гаргалаа.




Соёлын биет бус өвийн 7 ай савын хүрээнд иргэдийн хэрэглээний өнөөгийн байдлыг хувиар илэрхийлж үзэхэд хамгийн өндөр нь уламжлалт баяр наадам, зан үйл, ёс тоглоом наадгай, уриа дуудлага 27 төрөл 33.6%, хамгийн бага нь байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг 2 төрөл буюу 1 хувийг тус тус эзэлж байна.

Соёлын биет бус өвийн хэрэглээний өнөөгийн байдлыг 7 ай тус бүрийг хувиар илэрхийлэв






Уламжлалт арга ухаан



Мал маллах арга ухаан



Гар урлал

